

**“Монгол цаазын бичиг” монголчуудын эрх зүйн  
сэтгэлгээнд үзүүлсэн түүхэн нөлөө**

*Б.Баярсайхан (МУИС)*

Монголчууд эрх зүйн сэтгэлгээний уг сурвалж нь мөнх тэнгэрийг шүтэх үзэл болон төлөвшиж “монголчуудын оюун санааны хувьд нэгтгэж, ард түмний тусгаар тогтнол, эрх, эрх чөлөө, төрийн бат бэх оршихуйн үндэс болж”<sup>1</sup> байсан гэж судлаачид үздэг. Гэхдээ цаг хугацааны олон зуун жилийн шалгаралтанд ингэж төлөвшсөн нь монголчуудын байгаль дэлхийг танин мэдэх, аливаа үзэгдлийг “ёс” болгон тайлбарлаж түүнтэй холбоотой зан үйл хэвшин тогтсон юм. Тухайлбал: “Онгод шүтэх ёс”, “Овоо тахиx ёс”, “Сүнсэн шүтэх ёс” гэх мэт монголчуудын амьдралд зан заншлын хэм хэмжээ болон тогтсон ёс нэлээдгүй байна. Үүнээс “Овоо тахиx ёс” монголчуудын эртнээс үйлдэж ирсэн зан заншлын тогтсон хэлбэр бөгөөд “тэнгэрийг шүтэж, уул усанд аливааг даатган явж байсан тул олноор чуулж нэртэй уул, усыг тахигын орон болгон сонгож, хүндэтгэн тахидаг ... тийнхүү шүтээн болгон тахивал түүний чулуу, мод, газар шороо, өвс ургамал, загас жараахайг хөндөх хугалах, эвдэн сүйтгэх, барих алахыг хэрхэвч зөвшөөрөхгүй гэж шууд онгон дархан (“хориглох” Б.Б) болгож”<sup>2</sup> хэвшүүлэн мөрдүүлэх болсон нь Манж Дай Чин гүрний үед ч хэвээр хадгалагдаж байсан юм. Энэ нь ахуйн энгийн түвшинд хэрэглэгдэж байсан үзэл юм бол улс төрийн төвшинд “Тэнгэрийн үзэл” хэрхэн бүрэлдэн бий болсон талаар доктор Н.Лүндэндорж “Үүрэг дээдлэх сэтгэлгээний оюун санааны үндэс нь Эртний Хүннү нараас эх үндэстэй эзэн хааныг шүтэж, түүнийг тэнгэр язгууртай гэж үзэж байсан төв азийн нүүдэлчдийн төр ёсны сэтгэлгээтэй шууд холбогдоно. Эзэн хааныг тэнгэр язгууртай гэж үзэж, мөнх тэнгэрийг шүтэх үзэл Хятадын “тэнгэрийн хөвүүн” (тянь-цзы) хэмээх үзэл баримтлалаас уу, эсвэл тэнгэрийг шүтэх нүүдэлчдийн бөө мөргөлөөс үү, мөн түүнчлэн нүүдэлчдийн төр ёсны гүн ухаан уу гэдэгт өдгөө судлаачдын судалгааны үр дүн бүрэн дүүрэн хариулт хараахан өгөөгүй байна”<sup>3</sup>.

Тэгвэл иргэншлийн онолоор илүү өндөр хөгжилтэй, том соёл, иргэншлийн нөлөө бусад улс үндэстнүүдийн иргэншил соёлд нөлөөлөхгүй байж чаддаггүй шиг, том соёл иргэншлээс бага соёл иргэншлүүд мөн авч, суралцаж ирсэн болохыг үгүйсгэхгүй бөгөөд түүхийн олон зуун жилийн туршид хөрш зэргэлдээ хятад, манжийн улс төрийн нөлөө, соёлоос нүүдэлчин монголчууд ангид байхгүй нь тодорхой.

Английн түүхч Гарольд Лемб хятадын соёл монголд бүр эртнээс нөлөөлж байсан тухай тэмдэглэхдээ: “Хятад, Уйгар, персийн засаг захиргааны уламжлал нь Чингис хааны эзэнт улсын зохион байгуулалтад туслав. Чингис хаан энэ үйл хэрэгтээ Хятад, Уйгарын төрийн удирдлагын хамгийн шилдэг ухааныг авч хэрэглэв”<sup>4</sup> гэжээ. Тухайлбал: Күнзийн сургаал олон талаар нөлөөлснийг анзаарахад төвөгтэй бус. Эртний хятадад эрх зүйн эх сурвалжид ёс заншил, хууль


<sup>1</sup> Сэлэнгэ Х. XIII зууны Монголын төр, эх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. УБ., 2004. 29-р тал.

<sup>2</sup> Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 2002. 50-р тал.

<sup>3</sup> Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2003. 163-р тал.

<sup>4</sup> Гарольд Лемб. Дэлхийн эзэн Чингис хаан. УБ., 2003. 9 дэх тал.

цааз байхаас гадна зүйр цэцэн үг, нэр төртэй, эрх мэдэлтэй хүмүүсийн хэлсэн сургаал үгс багтаж байсан нь Монголын эрх зүйн үзэл, сэтгэлгээнд мөн нөлөөлжээ. 1600-аад оны сүүл үеэс Монголын эрх зүйн үзэл сэтгэлгээнд манж, хятадын эрх зүйн үзэл сэтгэлгээ хүчтэй нэвтрэх боломж бүрэлдсэн. Гэхдээ Манжийн Энх-Амгалан хааны гаргасан нэгэн зарлигт "Зарлиг шинэ дагасан Халх нарыг түр тэдний хууль ёсоор болго хэмээв. ..."⁵ гэсэн нь Монголчуудын эрх зүйн сэтгэлгээ, уламжлалт хууль цаазыг хүлээн зөвшөөрсний нэгэн баримт юм.



"Монгол цаазын бичиг" монголчуудын эрх зүйн сэтгэлгээнд үзүүлсэн түүхэн нөлөө нь нэгдүгээрт: хууль бүтээх үйл ажиллагаанд оруулсан өөрчлөлтүүд, хоёрдугаарт: Хятад, дорнодахины эрх зүйн сэтгэлгээний уг сурвалж туссан байдал, гуравдугаарт: ял, шийтгэл түүний хэлбэр агуулгад өөрчлөлт хийсэн нь монголчуудын зан заншлын эрх зүйн сэтгэлгээг халах гол үндсэн нөхцөлүүд болсон юм. Төр төрийн алба түүнийтэй холбоо бүхий харилцааг хуулиар зохицуулах болсон нь монголчуудын эрх зүйн сэтгэлгээнд оруулсан томоохон өөрчлөлтүүдийн нэг байсан. Өмнөх үеийн Монголын уламжлалт хууль цаазад тэр бүр зохицуулж байгаагүй харилцаа бөгөөд нэн ялангуяа язгуурын хэргэм зэрэг, албан тушаал нь

өв залгамжлагдсан байсан. Энэ үеэс дээрх харилцаануудыг хуулиар зохицуулах болж Манжийн төрийн бодлогоор Монголын төрийн албан хаагчдад зэрэг хэргэм олгодог болсон юм.

Доктор Н.Лүндэндорж "Монголчуудад үүргийн сэтгэлгээ түлхүү хөгжсөн ... Энэ мөн л "Сайн эр үүргийн тухай боддог, ядарсан эр ашгийн төлөө мөрөөддөг" гэсэн Күнзийн сургаалаас ангид биш гэдэг нь ойлгомжтой. Тийм учраас монголчуудын эрхийн сэтгэлгээнд хятадын эрхийн философи түүний дотроос Күнзийн сургаал, легизм хүчтэй нөлөөлсөн нь дамжиггүй. Энэ тухай профессор В.А.Рязановский тэмдэглэхдээ: "Монголчууд түүхийнхээ бүхий л үеийн турш Хятадтай байнгын харилцаатай байсаар ирсний 100 жилд нь тэднээс хараат байдалтай байж иржээ. Илүү өндөр хөгжилтэй хятадын соёл монголд нөлөөлөхгүй байж үл чадах бөгөөд, тухайлбал, арай сайн боловсруулагдаж, арай сайн хөгжсөн хятадын хууль цааз илүү энгийн зан заншлын шинжтэй монголчуудын хууль цаазад гарцаагүй нөлөөлсөн юм"⁶ гэжээ. "Монгол цаазын бичиг" нь дорнодахины сэтгэлгээнд тулгуурласан хэдий ч нүүдэлчин монголчуудын олон зуун жилийн "Үүрэг дээдлэх" сэтгэл зүйд-суурилсан юм.

Монгол улсын их хаан Лигдэнтэй хамтран зүтгэж асан Саган-сэцэний нэрлэснээр, "таван зуун цөвийн цаг ойр болсон буюу "Их улс эвдрэхүй цагт", Өндөр гэгээн Занабазар эвдрэл хямралдааныг ирт мэсээр бус, номын хүчээр эвлэрүүлэхийг хичээж "цагийг тохинуулагч буюу Жанлавцогзол" хэмээх сургаалаа айлджээ. Түүнд өгүүлэхдээ:

"Асар цөвүүн цагийн их харанхуй үлэмж бүрхсэн  
Аяа бидний муу цагийн амьтныг нигүүлсэхүйгээр аварна уу  
Атгагт муу үйл нисванисын үр цагтаа боловсорсны  
Аливаа зовлонгийн их гол бүхнийг амирлуулж  
Алалдан тэмцэх өс хонзон арилж  
Асрал энэрлээр сэтгэл зохилдохын  
Амгалан энхийн хотол чуулганыг дэлгэрүүлэн зохион соёрхоно уу?"⁹

⁵ Өмнөх үеийн Монголын хууль цаазын тухай "Монголчуудад үүргийн сэтгэлгээ түлхүү хөгжсөн ... Энэ мөн л "Сайн эр үүргийн тухай боддог, ядарсан эр ашгийн төлөө мөрөөддөг" гэсэн Күнзийн сургаалаас ангид биш гэдэг нь ойлгомжтой. Тийм учраас монголчуудын эрхийн сэтгэлгээнд хятадын эрхийн философи түүний дотроос Күнзийн сургаал, легизм хүчтэй нөлөөлсөн нь дамжиггүй. Энэ тухай профессор В.А.Рязановский тэмдэглэхдээ: "Монголчууд түүхийнхээ бүхий л үеийн турш Хятадтай байнгын харилцаатай байсаар ирсний 100 жилд нь тэднээс хараат байдалтай байж иржээ. Илүү өндөр хөгжилтэй хятадын соёл монголд нөлөөлөхгүй байж үл чадах бөгөөд, тухайлбал, арай сайн боловсруулагдаж, арай сайн хөгжсөн хятадын хууль цааз илүү энгийн зан заншлын шинжтэй монголчуудын хууль цаазад гарцаагүй нөлөөлсөн юм" гэжээ. "Монгол цаазын бичиг" нь дорнодахины сэтгэлгээнд тулгуурласан хэдий ч нүүдэлчин монголчуудын олон зуун жилийн "Үүрэг дээдлэх" сэтгэл зүйд-суурилсан юм.

⁶ Рязановский В.А. Монголчуудын хууль цаазны дурсгал бичгүүдийн түүхэн тойм. Их засаг хууль. УБ., 2000. 101 дэх тал.

⁷ Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. (Ерөнхий ба тусгай онолын шинжилгээ). УБ., 2003. 215-221-р тал

⁸ Саган-Сэцэн. Эрдэнийн товч /Ц.Насанбалжир хэвлэлд бэлтгэсэн/ УБ., 1960. 340-р тал.

⁹ Жавзандамба хутагтын намтрууд оршвой. УБ., 1995. 26-р тал. (Даваажанцан. Тийн удирдагч Жибзандамба их эрдэнийн намтар магтаалын үг сайн хувьтны сүсгийг сэргээгч оршвой)





"Монгол цаазын бичиг"-т "Түшмэл" гэдэг үгэнд тодотгол хийж, эрхлэх ажил үүргийн нэрийг оруулсан тохиолдолд манж нэрээр нь шууд орчуулаагүй хэрэглэсэн байна. "Монгол цаазын бичиг"-т хяфанд хамруулсан зохицуулалт нь "Вангууд ирэхэд нөхөд, хөтөч авч ирэх нь"<sup>22</sup> гэсэн зүйлд холбогдож байгаа бөгөөд "түшмэлийн тушаал..." гэсэн холбоо үгээр ихэвчлэн хэрэглэж байсан бололтой. Тэгэхээр "түшмэл" гэдэг нь хэргэм зэрэг бус албан тушаалын ерөнхий нэршил юм.

"Монгол цаазын бичиг" Хятад дорнодахины хэв ёс сурталаас хол хөндий дан ганц нүүдэлчдийн эрхийн сэтгэлгээнд тулгуурлаагүй болохыг нэгэнт дээр өгүүлсэн ч ер нь хятад дорнодахины ямар үзэлд тулгуурласан болохыг нягтлах нь зүйн хэрэг юм. Тэр дундаа "Монгол цаазын бичиг"-т эртний хятадын төрийн хүндэтгэлийн ёс, түшмэлийн ёс "Күнз"-ийн номлолд тулгуурласан хэв ёс тодорхой байр суурийг эзэлнэ. "Күнз"-д "Ёслолоор найр талбин улсыг засваас юуны бэрх байнам! Ёслолоор найр талбин улсыг засаж эс чадваас ёслолын хэрэг бас юун байнам!"<sup>23</sup> гэсэн номлол "Монгол цаазын бичиг"-ийн "Мөргөхөөр ирэх, барихаар ирэхийн зүйл" хэмээх гутгаар дэвтэрт шинжилгээ хийвэл "Жил бүр есөн цагаан барих нь" гэсэн нэгэн зүйлд "Нэгэн зүйл. Халхын Түшээт хан хийгээд Сэцэн хан, Живзундамба хутагт жил бүр цагийн алба нижгээд цагаан тэмээ, наймаад цагаан морь барихаар ирэхэд гучаад лан мөнгө, домбо нижгээд, цар нижгээд, торго гучаад, хар бөс далаад шагнана"<sup>24</sup> гэжээ. Үнэндээ бол Манж Дай Чин улсаас өмнө Монголын төрийн ёслолд тогтоосон хэмжээгээр тэр бүр энэ мэт төрийн ёслолыг нарийвчлан тогтоосон хэм хэмжээ байсан боловч одоогоор нягтлан шинжилж нэгдсэн ойголтод хүрээгүй л байна. Энэ мэт "Монгол цаазын бичиг"-ийн гуравдугаар дэвтэр нь бүхэлдээ "Ёслолоор найр тавин улсыг засах" тухай "Күнз"-ийн номлолын үзэл санаанд тулгуурласан байж болох талтай.

Мөн Манж Дай Чин гүрний үед эрүүгийн ял шийтгэлийн бодлого хатуу чанга болж монголчуудын хэрэглэж байсан уламжлалт ял шийтгэлийг авч хэрэглэсэнээс гадна ял шийтгэлийн олон төрөл зүйл, тухайлбал: "огжиж алах, чавчин алах, хөвчдөн алах, амийг хороосны дараа толгойг шонд өлгөж түмэн олонд үзүүлэх" гэх мэт эрүүгийн ялууд нэмэгдсэн нь дээрх бодлогыг гэрчлэх юм. Гэтэл "Күнз"-д "Засаглалаар хөтөлж, хууль цаазаар цэгцлэвээс эгэл ард гэм ял үйлдэхээс зайлсхийх боловч гэмших сэтгэл эс төрмүй."<sup>25</sup> гэж номлосон нь ял шийтгэлийг хатуу чанд байлгах хятадын эртний ёс "Монгол цаазын бичиг"-ийг тойрсонгүй харин ч утга агуулгын хувьд хэрэгжих боломж бүрэлдэн тогтсон байна. Ингэж эрүүгийн ял шийтгэлийг нэгэн мөр хатуу чанга болгосон ч монголчуудын тусгай эрхийн харилцааг "Монгол цаазын бичиг"-ийн зохицуулалт тэр бүр нарийн хамарч чадаагүй байна. Мөн "Ёс суртлаар хөтөлж, ёслолоор цэгцлэвээс эгэл ардад гэмшин ичингүйрэхүйн сэтгэл төрөх төдийгүй, эрхбиш эрхшээн дагамуй"<sup>26</sup> гэж "Күнз"-ийн сургаалд тулгуурлан нүүдэлчдийн нэгт тогтсон ёс, зан заншил, эрх зүйн сэтгэлгээг "Монгол цаазын бичиг"-т тусгасан байдаг. Тухайлбал: "Монголчууд худ боллоцоход богтлох мал өгөх" гэх мэт,

Ер нь монголчууд Манж Дай Чин улсын эрхшээлд орсноор тэдний зүгээс гаргасан хууль цаазууд Ж.Цэвээний тэмдэглэсэнээр монголчуудын ёс заншил, уламжлалт хуулиудад үлэмжхэн хэмжээгээр тулгуурласан байсныг нэг талаас монголчууд өөрийн өвөрмөц онцлог бүхий үзэл, сэтгэлгээ, соёл баттай бүрэлдэн хөгжсөнийг харуулахын зэрэгцээ В.А.Рязановскийн дүгнэснээр нэгдүгээрт, нүүдлийн ахуй амьдралтай монголчуудын аж байдал нь Монголд зориулсан Манж-Хятадын хууль тогтоомжийн цар хүрээнд багтаж, шингээгүйн улмаас гүнзгий уламжилсан байж болох юм. Хоёрдугаарт, монголчуудын эрх зүйн сэтгэлгээ, тогтолцоонд Хятадын хууль цаазын нөлөө хүчтэй, манжийн хэл, бичиг, соёл олон талаар адил төстэйн улмаас монголын уламжлалт хуулиудын үндсүүдийг хадгалсан. Гуравдугаарт, Монголын цэргийн хүчийг Хятадын эсрэг ашиглаж хооронд нь эвсүүлэхгүй байх гэсэн Манж Дай Чин гүрний төрийн бодлого нь монголчуудын тухайд зарим талаараа аядуу зөөлөн хууль цаазын бодлого баримтлахад хүргэсэн байж болох юм. Гэхдээ В.А.Рязановскийн дүгнэлтэд зарим нэгэн талаар шүүмжлэлтэй хандах нь зүй хэрэг бөгөөд олон зуун жилийн дотоодын самуун, тэмцэлдээнээс залхсан Халх

<sup>22</sup> mongyol cayaajin-u bicig (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. 01.63a.4-01.68a.2

<sup>23</sup> Күнз. Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан Урианхан овогт Мэнэрэлийн Чимэдцэеэ. УБ., 2004. 39-р тал.

<sup>24</sup> mongyol cayaajin-u bicig (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. 01.61b.3-01.62a.1

<sup>25</sup> Күнз дээрх бүтээлийн 27-р тал.

<sup>26</sup> Мөн дээрх талд.

Монголын нийгэм дахин Манж Дай Чин эсрэг зэвсэг барин тэмцэх санаа бодлыг нэгэнт хүлээн авахааргүй болсон байв.

Мөн түүхч Ц.Сономдагва "Манжаас тогтоосон "Монгол цаазын бичиг", "Гадаад монголын төрийг засах яамны хууль зүйлийн бичиг" гэдэг хоёр төрлийн хууль цаазыг гадаад монголын олон аймаг, хотууд нийтээр даган биелүүлж байсан боловч үүний хажуугаар орон нутгийн хэв хууль ч үйлчилж байсан байна"<sup>27</sup>. Гэвч Манж Дай Чин улсын үед Монголын хууль цаазыг ялгавартайгаар (жишээ нь их шавийн хэрэг шийдэхэд) хэрэглэж ирсэн гэсэн дүгнэлтийг олон эрдэмтэд<sup>28</sup> хийсэн байдаг.

Япон улсын судлаач Мамору Хагихара уг асуудлыг нарийвчлан судалж арай өөр дүгнэлт хийсэн байна. Түүний судалгаагаар "Их шавь"<sup>29</sup>-ийн хэрэг шийдэхэд эхний үед Халх журамыг, дараа нь "Халх журам", "Монгол цаазын бичиг"-ийг, сүүл үе рүү Манж Дай Чин улсаас Ар Монголд зориулж гаргасан хууль цаазуудыг (гэхдээ Улаан хацартыг ашигласаар байсан) ялын хүнд хөнгөнийг үл харгалзан хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ашиглаж байсан<sup>30</sup> гэж дүгнэсэн нь Манж Дай Чин гүрний хууль цааз нь монголын хууль цаазад хэдийвээр олон зүйлээр тулгуурласан хэдий ч аажим аажмаар Монгол хууль цаазыг халж, сумын ард, хамжлага, шавь, их шавийн хэргийг шийдэхэд цөм Манжийн хууль цаазыг хэрэглэдэг байжээ. Гэхдээ манжийн хуулиуд монголд хэрэгжих боломжтой юу? гэдэг асуултад судлаачид хараахан хариулт өгөөгүй. Ер нь бидэнд уламжлан ирсэн манжийн хууль цаазын эх сурвалжид мөрдүүлэхээр тогтоосон хэмээн үзэж байгаа ч түүний үр нөлөө ямар түвшинд байсныг шинжлэх нь чухал байна. Өөрөөр хэлбэл манжийн аль ч цаазын бичгүүдэд "Отог"<sup>31</sup>-ийн тухай өгүүлээгүйгээр барахгүй, түүний доторх нийгмийн харилцааг хэрхэн зохицуулж байсан талаарх судалгаа бүрхэг хэвээрээ л байна.

Эл үед монголчуудын үеийн үед уламжилж ирсэн хууль цаазын уламжлал сулрах хирээр өөрийн уламжлалт хууль цаазыг Манжийн хууль цаазтай харьцуулах, Манжийн хуулийн харгис хатуу чанарыг мэдрэх тусам хууль цаазын үндэсний уламжлалаа танин мэдэх, үнэлэх, хадгалах сэтгэлгээ сэргэж хөгжсөн нь маргаангүй. Монголчууд энэ үед хууль цаазад туссан Манжийн суртлыг хүлээн авахгүй, дагаж мөрдөхгүй байх зэргээр уламжлалт үзэл соёлоо хадгалсаар байсан байна. Нэн ялангуяа олон зуун жилээр хэвшин тогтсон хэв хууль, заншлын эрх зүйн сэтгэлгээгээ хэвээр хадгалсаар байлаа. Гэхдээ зарим тохиолдолд манж зүрчидийн зан заншлын уламжлалыг авч хэрэглэсэн хэдий ч түүнийг эсэргүүцэх бодлого нийгмийн бүхий л давхаргад хүчтэй хэвээр байсныг доктор З.Лонжид "Ойр төрлийнх нь хүмүүс нас нөгчсөн үед монголчууд манж, хятад хүний адил цагаан хувцас өмсөж дээд тал нь гурван жилийн турш эмгэнэл бэлбэсрэл үйлдэх болжээ. Гэвч монголчууд энэ зан үйлийг төдий л хүлээж авахгүй байсаар 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын дараахан Халхын Түшээт хан Дашням нас

<sup>27</sup> Сономдагва Ц. Манжийн захиргаанд байсан үеийн ар монголын засаг захиргааны зохион байгуулалт. УБ., 1961. 23 дахь тал.

<sup>28</sup> Riasanovsky V.A. Fundamental Principles of Mongol Law. Tientsin. 1937. /1924 он хүртэл дан халх журмыг баримтлаж их шавийн хэргийг шүүж байсан гэсэн санал/ Дылыков. С.Д. Халх джирум. М., 1965. С. 339. /бас дээрхтэй ижил санаа дэвшүүлсэн/, Жанадагийн /Япон эрдэмтэн/ Халх журмаас монгол цаазын бичигт шууд шилжсэн гэсэн санал, С.Жалан-Аажав. Халх журам ба монголын хууль цаазын эртний дурсгал бичиг. УБ., 1958. 115 дахь тал. /Бусад чуулганы хэрэгтэй холбогдсон хэргийг дан монгол цаазын бичгээр, их шавийн хэргийг Халх журам, Улаан хацартыг хамт ашиглаж шүүж байсан/, Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн ар монголын засаг захиргааны зохион байгуулалт. УБ., 1961. 131 дэх тал /хөнгөн ялтай гэмт хэргийг Халх журам ба Улаан хацартаар, хүнд ялтай гэмт хэрэгт Манжийн хуулийг баримталж шүүдэг байсан/.

<sup>29</sup> ХҮII зууны үед бий болсон засаг захиргааны нэгж. "Шавь" гэдэг нь хутагт нарт үйлчилж байсан хамжлага ард. "Өндөр гэгээн ба Эрдэнэ зуугийн намтар", "Жавзандамба ламын төрөл үеийн нэрс хийгээд орон дацан байгуулсан тэмдэглэл", "Өндөр гэгээний уг эх хийгээд тэр үеийн манжийн хаадын зарлиг тушаал мэтийн чухал хэрэг зүйлийг цуглуулан бичсэн дэвтэр", "Дээрхийн уг эх" зэрэг түүхэн эх сурвалжид дурьдсанаар: 1640 онд Өндөр гэгээн Занабазарыг Монголын шарын шашны тэргүүн анхдугаар Богд болгон өргөмжилж хаан ширээнд залж суулган, түүнд лам, хар шавь, хамжлага таслан өгснөөр "Их шавь"-ийн анхны үүсэл буй болгожээ.

<sup>30</sup> Мамору Хагихара. Манж-Чин улсын үеийн Монгол дахь Их шавийн гэмт хэргийг шүүсэн хууль цааз. Монголч эрдэмтдийн IX хуралд хэлэлцүүлсэн илтгэл. УБ., 2002.

<sup>31</sup> ХҮ-ХҮI зууны үед бүрэлдсэн засаг захиргааны нэгж. "Отог" хэмээх үгийн тухайд бол "От" гэдэг нь түрэг хэлэнд "Гал" гэсэн үг. Б.Я.Владимирцов "Отог"-ийг газар нутаг хэмээх согд гаралтай үг гэж тайлбарласан (Владимирцов Б.Я. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. М. 1934. С. 134). "Отог" гэдэг үгийг эртний түрэг хэлний тайлбар толинд "отаг" нь "гэр", "чачар" хэмээх утгатай үг гэж тайлбарласан байна (Древнетюркский словарь. Л. 1969). Судлаачид отгийг "гал", "голомт", "өрх", "гэр" хэмээсэн утга бүхий Монгол үг гэж үзсэн байна (Нацагдорж Ш. Феодализмын үндсэн замнал. УБ., 1978. 147-р тал). Монгол Ойрдын их цаазад (1640) "...отог отгийн түшмэл" гэж гарч байгаа нь тухайн үед отог гэдэг нь засаг захиргааны нэгж байжээ.

нөгчихөд Богд хаан зарлиг буулгаж урьдын ёсоор цагаан хувцас өмсөж болохгүй. Харин түүний хойчийн буянд ном гүрэм унших, өглөг үйлдэхийг дотроод яаманд мэдэгдсэн байдаг”<sup>32</sup> гэж дурдсан байна.

Энэ нь монголчуудад эрх зүйн уламжлалт сэтгэлгээний хүрсэн төвшингөө хадгалан хөгжүүлэх, хамгаалах үзэл санааг гүнзгийрүүлснээс гадна хууль цаазын эртний уламжлалт соёлтой Хятадын эрх зүйн нөлөөгөөр хууль боловсруулах арга технологи, нийгмийн харилцааг төрөлжүүлэн ангилж хуульчлах (Хавсралт) зэргээр эрх зүйн үзэл, сэтгэлгээнд ахиц өөрчлөлтийг агуулсан байж болох юм. Хууль цаазыг ангилан тогтоох, төрөлжүүлэх нийтлэг арга, технологи эл цаг үед орж ирсэн гэдгийг “Хуулийг өөр өөрийн ангийн хойно бичиж, үүгээр олон ялыг төвшин болгож...”<sup>33</sup> байсан нь “Монгол цаазын бичиг”-т бүтцийг ажиглахад хэрхэн хэрэгжүүлсэнийг төвөггүйхэн харж болно.

Зөвхөн Манж Дай Чин гүрний эрхшээлд байсан гэдгээр эрх зүйн үзэл, сэтгэлгээнд харанхуй буюу ухарч доройтож, уламжлалт соёл, үзлээ алдсан гэж үзэж хараахан боломжгүй санагдана. Наандаж л хуулинд төр, иргэн захирагдах тухай үзэл санаа хүртэл “Монгол цаазын бичиг”-т байгааг анзаарахгүй өнгөрөхийн аргагүй юм. Тухайлбал: “Зарлигийг дагаж цэргийн тухайн сайдууд Шүүх явдлын яам, Гадаад Монголын төрийг засах явдлын яамны лугаа айлтгаад тогтоосон хууль, Үүнийг үүрд хууль болго хэмээв” зэргээр зарчимын шинжтэй нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоож байгаагаа тунхагласан нь дээрх санааг нотлох биз дээ.

Хүн төрөлхтөний түүхээс үзэхэд колони орны зовлон бэрхшээл хэдийгээр хүнд бэрх боловч колонийн эзэн орон нь тухайн колончлогдож буй орноос иргэншил соёл, хүч чадлаар ямагт давуу байдаг учир, түүний нөлөөгөөр дэвшил, өөрчлөлт ч мөн дагалдаж байдаг нь түүхийн үнэн билээ.

Эл цаг хугацааны хувьд монголын оюун санааны амьдрал “сэргэн мандалттай” давхцаж байсан учраас буддын гүн ухааны нөлөө, дэлгэрэлтээр монголчуудын гүн ухааны сэтгэлгээ гүнзгийрэн хөгжиж, Манж Дай Чин гүрний түрэмгийллийн эсрэг үндэсний тусгаар тогтнол, дотоодын хямрал зөрчилдөөний эсрэг эв нэгдлийн үзэл санааг эрхэмлэн дээдэлж, “нийгмийн амьдралаар дэвшин гарсан зангилаа асуудлуудыг товойлгон тавьж боловсруулсаар, гүнзгийрэн урагшилсаар ирж”<sup>34</sup>, “аливаа асуудлыг төр ёсны эрх ашигт нийцүүлэн авч шийдвэрлэх явдал эл үеийн нийгмийн дэвшилтэт сэтгэлгээний үндсэн агуулга, хандлага болж”<sup>35</sup> байсан нь эрх зүйн үзэл, сэтгэлгээ ч үүнийг тойроогүй нь магад юм. Хэдийгээр Монголын эрх зүйн түүхэнд ХҮИ зуунаас эхлэн бурханы шашны үзэл сэтгэлгээ хууль цаазад нөлөө бүхий байсныг эл үеэс хязгаартайгаар авч үзэн “Лам нарын хуулийн зүйл”<sup>36</sup> гэж тусгайлан зохицуулж харин бусад зүйлд бурханы шашинтай холбоо бүхий зохицуулалт, үг хэллэг, номлолыг бараг хэрэглэж байгаагүй нь төр, шашны асуудлыг тусгаарлан хязгаартайгаар хандаж байсны илрэл юм.

Тийм учраас монголчуудын эрх зүйн сэтгэлгээнд үндэсний ухамсар, үзэл улам лавширан гүнзгийрч өөрийн түүхэн хууль цаазын үнэт зүйлсийг дахин үнэлэх, хадгалан бэхжүүлэх явдал хүчтэй болсон гэж үзэж болно. Эл үеийн монголын хууль цаазыг зохиох, боловсруулах үйл явцад хамтын зарчим харьцангуй хэрэгжиж байсан нь монголчуудын хууль цаазын үндэсний үзэл, сэтгэлгээг тухайн үеийн хууль цаазад тусгах, хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байсан гэх үндэстэй мэт санагдана. Тухайлбал, Тэнгэрийг тэтгэгч 1766 онд “Монгол цаазын бичиг”-ийн холбогдох заалтыг тогтоохдоо: “...Шүүх явдлын яам, Гадаад монголын төрийг засах яамны лугаа нийлж Шан Шигийн шүүгч Солины айлтгасаныг дахин хэлэлцээд айлтгаж тогтоосон хууль”<sup>37</sup> гэж тэмдэглэснээс харагдана.

<sup>32</sup> З.Лонжид. Манжийн үеийн түүхийн нэгэн чухал сурвалж. “Манжийн эрхшээлийн үеийн Монгол” эмхтгэл. УБ., 2004. 69-р тал.

<sup>33</sup> Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. УБ., 2002. 26 дахь тал.

<sup>34</sup> Жүгдэр Ч. XV-XVIII зууны монголын гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ., 1984. 18 дахь тал.

<sup>35</sup> Монголын философийн түүх. II дэвтэр. УБ., 2000. 373 дахь тал.

<sup>36</sup> монгол сагајин-и бицг (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. 04.14а.3-04.18а.4

<sup>37</sup> монгол сагајин-и бицг (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. 242-р тал. 04.40b.7-04.31a.3.

Судлаачид "Их засаг" цаазыг харгис хатуу гэж үзэж заншсан нь бас ч тийм биш бололтой. Академич С.Нарангэрэлийн бүтээлдээ "Сүсэг бишрэлгүй бөгөөд Аллахын замаас хазайсан" хүмүүсийн тухайд гэвэл ажил хэрэг нь дээрхийн соёрхлоор "төөрөгдөлд" орж, "өөдгүй муу үйлд өртөн, нөхцөл байдал нь муудах аюул заналхийлнэ". "Өршөөн нигүүлсэгч, энэрэнгүй сэтгэлт Аллахын нэрийн өмнөөс, чин итгэл үнэн сүсэггүй этгээдтэй та учирваас сэлмээр хүзүүг нь тас цавчигтун. ..." <sup>38</sup> гэж өгүүлснийг үндэслэвэл Дорнодахин, Өрнийн эрх зүйн сэтгэлгээнээс хатуу зөвхөн "Коран" хэмээх судрын үнэлэмжээр хүн, нийгмийн бүхий л харилцааг журамлаж зохицуулж байдаг нь бусад эрх зүйн бүлээс ялгарах гол онцлог нь юм. Гэхдээ эртний Хятадын хууль цааз дээрхээс илүү харгис хатуу байжээ. Нэн эртнээс Хятадын эрүүгийн хууль цаазад нүүрийг тамгалах, хамрыг огтлох, хөлийг тайрах, агтлах (хөнгөлөх), алах гэсэн таван төрлийн цааз байсан байна. МТӨ мянган жил орчмын өмнө залхаан цээрлүүлэх бүхэл бүтэн тогтолцоог бүрдүүлж 3000 гэмт хэрэг заагдсаны алах ял 200, огтлох 300, хөлийг тайрах 500, хамрыг огтлох 1000, тамгалах 1000, түүнээс гадна мэргэшсэн аргаар алах ял байжээ. <sup>39</sup>

Эдгээртэй харьцуулбал "Их засаг" цаазтай хатуу боловч энгийн, эрэмдэг болгох, мэргэшсэн аргаар үхүүлэх зэрэг ял хэрэглэдэггүй байсан учраас "...хатуу хууль" гэж болохгүй нь харагддаг. <sup>40</sup>

"Их засаг" цаазаас хойших Монголын уламжлалт хууль цаазуудад алах ялын төрөл, тоо цөөрсөөр ирсэн билээ. Харин Манж Дай Чин гүрний захиргаанд орсон үеэс Хятадын эрх зүйн нөлөөгөөр "Цаазыг чанга болговол сая цээрлэл үзүүлж чадна" <sup>41</sup> гэсэн үзэл, зарчим нэвтэрсэн бололтой. Тухайлбал, "Монгол цаазын бичиг"-т олон төрлийн ялыг нэмснээс гадна алах ял "хөвчдөн алах, цавчин алах, огтчин алах" гэсэн гурван төрөлтэйгөөс гадна боол болгох, цөлөх, шоронд хорьж үхүүлэх зэрэг Монголын уламжлалт хууль цаазад тэр бүр байгаагүй, байсан ч өргөн хэрэглэж байгаагүй ялуудыг хэрэглэж ирсэн байна. "Монгол цаазын бичиг"-т "харц хүн хатад лугаа явалдвал явалдсан эрийг огтчин алсугай. Хатныг цавчин алсугай. Явалдсан эрсийн эм, хөвгүүдийг боол болгон өг" <sup>42</sup> гэсэн байна.

Манж Дай Чин улсын үеийн эрх зүйн бодлого, соёлын нөлөөнд байсан цаг үед монголчуудын тусгай эрх буюу иргэний эрх зүйн сэтгэлгээ ахуйн хүрээг шууд тусгасан "хэв хууль"-ийн хэмжээнд уламжлалт шинжээ хадгалсаар байсан. Энэ нь "Монгол цаазын бичиг"-т иргэний эрх зүйн харилцааг зөвхөн дээр өгүүлсэнчлэн "Эрх зарлага" хэмээх 2-р дэвтрийн зарим нэгэн зүйлийг хамааруулж болохоос өөрөөр зохицуулалт байхгүйгээс харагдана. Ингэж зохицуулсан нь тусгай эрхэд холбогдох харилцааг зохицуулах шаардлагагүй гэж үзсэнээс бус, харин монголчуудын өөрсдийн хууль цаазыг үргэлжлүүлэн үйлчлүүлэх Манж Дай Чин гүрний төрийн бодлоготой холбоотой байж болох талтай. Үүнийг нотолсон баримт Манжийн Энх-Амгалан хааны зарлигийг дахин өгүүлж болох юм.

Эдгээрээс дүгнэвэл Манж Дай Чин гүрний захиргаанд байсан үеийн монголчуудын эрх зүйн сэтгэлгээнд:

**Нэгдүгээрт**, өөрийн үндэсний уламжлалт хууль цаазын үзэл, сэтгэлгээний үнэт зүйлсийг улам гүнзгий ухамсарлаж мэдэх, хадгалан бэхжүүлэх үндэсний ухамсрыг сэргээсэн байна. Үүний үр дүнд зөвхөн Монголд зориулж хууль батлуулж чадсан, өөрсдөө 1709 онд "Гурван хушууны Их цааз" буюу "Халх журам"-ыг баталж мөрдөх болсон.

**Хоёрдугаарт**, Манж, Хятадын эрх зүйн сэтгэлгээ, соёлын нөлөөгөөр суурин иргэншилт, хууль цаазын эртний уламжлалт орны хууль боловсруулах арга, ажиллагаа, нийгмийн харилцааг хуулиар зохицуулахдаа ангилан, төрөлжүүлж зохицуулдаг, нийтэд түгээмэл хэрэглэдэг хууль цаазын зарим нэр томъёог авч хэрэглэх, дахин сэргээх зэргээр өөрсдийн хууль цаазын мэдлэг, үзэл сэтгэлгээгээ хөгжүүлсэн байна.

<sup>38</sup> Нарангэрэл С. Монголын ба дэлхий эрх зүйн тогтолцоо. УБ., 2004. 255-р тал.

<sup>39</sup> Рязановский В.А. Дурьдсан зохиол. 83-84 дэх тал.

<sup>40</sup> Рязановский В.А. Дурьдсан зохиол. 84 дэх тал.

<sup>41</sup> mongyol sayajin-u bicig (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. 150-р тал. 02.51b.6-02.51b.7

<sup>42</sup> mongyol sayajin-u bicig (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. 222-р тал. 04.11a.5-04.11b.1



**Гуравдугаарт:** төрийн албаны тогтолцоо, албан тушаалтнуудын зэрэг хэргэмийг хуулийн хүрээнд баталгаажуулж өгсөн нь түүний нэр хүндийг өргөх, хуулийн хүрээнд ажиллах төрийн албаны ёс зүй цаашид төлөвших үндэсийг тавьсан байна.

**Дөрөвдүгээрт,** цааз чанга байвал цээрлэлийн үр нөлөө дээшилнэ гэсэн Хятад, Дорнодахины үзэл, зарчим Манж Дай Чин гүрний хууль цаазын нөлөөгөөр хүссэн ч, хүсээгүй нэвтэрч, монголын эрх зүйн үзэл, сэтгэлгээнд урт удаан хугацаагаар хадгалагдах үндсийг тавьсан байна.

**Тавдугаарт,** тусгай эрх буюу иргэний эрх зүйн харилцааг эл үеийн хууль цаазад төдийлөн нарийн зааж тусгаагүй орхисон нь монголчуудын иргэний эрх зүйн уламжлалт зохицуулалтыг урт удаан хугацаанд заншдын эрх зүйн хүрээнд хадгалагдах шалтгаан болсон байна.

**Зургаадугаарт:** Манай судлаачдын монголын төр, хууль цаазад холбогдох ном зохиолд эл үеийн хууль цаазын сэтгэлгээг ихэвчлэн тусгаагүй буюу бага тусгасан байдал ажиглагддаг. Бодвол "Монгол хууль" биш гэсэн үзэл давамгайлж байсных биз ээ. Гэвч монголчууд түүнийг багагүй хугацааны туршид даган мөрдөж байсан гэдгийг бас мартаж болохгүй. Нөгөө талаас харийн хүн гадны нүдээр монголчуудад ямар хууль чухал гэдгийг анхаарч тооцсон байдал, монголчуудын эрх зүйн үзэл, сэтгэлгээнд үлдээсэн эерэг, сөрөг зүйлийг олж мэдэхэд болон монголчуудын хууль цаазаас орхиж болохгүй заавал хадгалж үлдэх ямар эрх зүйн сэтгэлгээний өв соёл байв гэдгийг гадныхан хэрхэн тусгаж байв гэдгийг тусгайлан судлахад ач холбогдолтой юм.

## НОМ ЗҮЙ

1. *ᠪᠢᠭᠡᠷ ᠳᠠᠶᠢᠯᠵᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠵᠢᠨᠠᠭᠤᠨ ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭᠤᠨ* "Биеэр дайлж өрнө, умарын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг. Хөх хот. 1992.
2. Гарольд Лемб. Дэлхийн эзэн Чингис хаан. УБ., 2003.
3. Дылыков. С.Д. Халх джирум. М., 1965.
4. Жавзандамба хутагтын намтрууд оршвой. УБ., 1995.
5. Жалан-Аажав С. Халх журам ба монголын хууль цаазын эртний дурсгал бичиг. УБ., 1958.
6. Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 2002.
7. Күнз. Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан Урианхан овогт Мэнэрэлийн Чимэдцэеэ. УБ., 2004.
8. Лонжид З. Манжийн үеийн түүхийн нэгэн чухал сурвалж. "Манжийн эрхшээлийн үеийн Монгол" эмхтгэл. УБ., 2004.
9. Лувсанжав Г., Шархүү Г. Манж Монгол толь бичиг. УБ., 1968.
10. Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2003.
11. *ᠪᠢᠶᠢᠰᠠᠶᠢᠬᠠᠨ ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭᠤᠨ* "ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ" 1᠘᠖0 — ᠠᠨᠤ Монгол үгсийн язгуурын толь. Хөх хот. 1981.
12. mongyol baiajin-u bicig (Эх бичгийн судалгаа) Тэргүүн дэвтэр. УБ., 2004. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Б.Баярсайхан. Эрхлэн хэвлүүлсэн Ц.Шагдарсүрэн, Ж.Гэрэлбадрах.
13. Монголын философийн түүх. II дэвтэр. УБ., 2000.
14. Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. УБ., 2002.
15. Нарангэрэл С. Лүндэндорж Н. Эрх зүй судлалын удиртгал. УБ., 2002.
16. Riasanovsky V.A. Fundamental Principles of Mongol Law. Tientsin. 1937.
17. Рязановский В.А. Монголчуудын хууль цаазны дурсгал бичгүүдийн түүхэн тойм. Их засаг хууль. УБ., 2000.
18. Саган-Сэцэн. Эрдэнийн товч /Ц.Насанбалжир хэвлэлд бэлтгэсэн/ УБ., 1960.
19. Сономдагва Ц. Манжийн захиргаанд байсан үеийн ар монголын засаг захиргааны зохион байгуулалт. УБ., 1961.
20. Сэлэнгэ Х. XIII зууны Монголын төр, эх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. УБ., 2004.
21. *ᠪᠢᠶᠢᠰᠠᠶᠢᠬᠠᠨ ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭᠤᠨ* "ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ" 1994, Хорин нэгтийн тайлбар толь.
22. *ᠪᠢᠶᠢᠰᠠᠶᠢᠬᠠᠨ ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭᠤᠨ* "ᠲᠤᠭᠳᠤᠰᠤᠨ" ᠑᠙᠘᠓ — ᠑᠙᠘᠔ "ᠪᠢᠶᠢᠰᠠᠶᠢᠬᠠᠨ" "Хятад Монгол толь. (Нэмэж засварласан дэвтэр) Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1983.